



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2015 оны 03 сарын 05 өдөр

Дугаар Б/06

Улаанбаатар хот

Г Захирамжлалын баримтад цахим хувь Г  
үйлдэх ажилтан томилох тухай

Нийслэлийн Засаг даргын А/452 дугаар захирамж, Хөдөлмөрийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 50 дугаар зүйлийн 50.1, Газрын дүрмийн 5.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Холбоо мэдээлэл технологийн инженер Г.Цэнджавыг 2015 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн захирамжлалын баримтад цахим хувь үйлдэх ажлыг нэмэлтээр гүйцэтгүүлсүгэй.

2. Г.Цэнджавыг хөдөлмөрийн гэрээгээр нэмэлтээр гүйцэтгэсэн ажлын цалинг үндсэн цалингийн 30%-аар нэмэгдүүлэн тооцож олгохыг нягтлан бодогч /Г.Батням/-д зөвшөөрсүгэй.

3. Ажлын хэрэгжилт, зохион байгуулсан ажлын тайлан мэдээг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор Нийслэлийн архивын газарт тогтмол тайлагнаж ажиллахыг Холбоо мэдээлэл технологийн инженер /Г.Цэнджав/-т үүрэг болгосугай.

4. Инженер Г.Цэнджав-тай нууц хадгалалтын гэрээ байгуулан, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагааны албаны дарга-д даалгасугай.

ДАРГА  М.БОНЧИГЖАВ

31506C0009